СЭЛЭНГЭ
ЭРҮҮЛ МЭНДИЙН
ГАЗАР

# БАЙГУУЛЛАГЫН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

| № | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | алгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэл хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| **1."Эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого, Эрүүл мэндийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, арга зүйн дэмжлэг үзүүлэх** | | | | | | | |
| **Зорилт-1: Хүний нөөцийн хангалт, сургалт, шагнал урамшуулал, нийгмийн баталгааг хангах** | | | | | | | |
| 1.1.1 | Эмч, эмнэлгийн мэргэжилтний хүрэлцээ хангамжийг нэмэгдүүлж. тасралтгүй сургаж хөгжүүлэх | Улс, орон нутаг,Олон улсын байгууллагын санхүүжилт | Ажилд шинээр орсон эмч эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны тоо | 194 | 1% хүртэл нэмэгдүүлнэ | 2025 онд эрүүл мэндийн салбарт 34 их эмч, 53 эмнэлгийн мэргэжилтэн, 50 туслах ажилтан шинээр орж хөдөлгөөн хийгдсэн байна. Глобал удирдагч их сургуулийн харьяа Сувилахуйн сургуультай хамтран ажиллангаа суралцах нөхцөлөөр 10 туслах сувилагчийг мэргэжил дээшлүүлэн суралцахад дэмжлэг үзүүлэн бакалаврын боловсрол эзэмшүүлэн ажлын байраар ханган ажиллалаа. 2025-2026 оны хичээлийн жилд магистр 5, эм зүй 6, туслах сувилагч 3 эмч, эмнэлгийн мэргэжилтэнг ажиллангаа суралцах нөхцөлөөр дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. | 100 |
| | | | Ажлын байр болон зайн сургалтад хамрагдсан мэргэжилтний хувь | 100% | 100% | Салбарын хэмжээнд 158 удаагийн цахим сургалтад давхардсан тоогоор 2100, ажлын байрны сургалтад давхардсан тоогоор 5170, зайн буюу телемедицины сургалтад давхардсан тоогоор 862 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан. | 100 |
| 1.1.2 | Эрүүл мэндийн ажилтны нийгмийн баталгааг сайжруулан, орон нутагт тогтвор | орон нутаг төсөв,хандивлагч байгууллага | Нийгмийн баталгаа нэг удаагийн тэтгэмжид хамрагдсан албан | 12,8 | 1% хүртэл нэмэгдүүлнэ | Эмч эмнэлгийн мэргэжилтэнг хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажиллуулах ажлын хүрээнд эрүүл мэндийн тухай хуулийн 29.5 дах заалтын дагуу 141 эмч, эмнэлгийн мэргэжилтэнд 1,166,442,000 сая төгрөг, 29.2 дах заалтын дагуу 38 хүнд 1,333,437,681 сая төргийн тэтгэмжийг олгосон байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | суурьшилтай ажиллах чиглэлээр орон сууц, гэрээр хангах, малжуулах арга хэмжээ хэрэгжүүлнэ. | | хаагчийн хувь | | | | |
| | | | -Орон сууцаар хангагдсан, орон сууцны зээлд хамрагдсан ажилтны тоо | 2 | 20 | Орон сууцны зээлд шинээр 11 албан хаагчийг хөнгөлөлттэй нөхцөлөөр, иж бүрэн гэрээр 3 албан хаагчид дэмжлэг үзүүлсэн байна. | 100 |
| 1.1.3 | Эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудыг ажиллангаа суралцан мэргэжил дээшлүүлэх, үндсэн болон төрөлжсөн мэргэшил эзэмших, мэдлэг, ур чадварыг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн гадаад, дотоод сургалтад хамруулах | Улсын төсөв | Ажлын байранд суралцсан албан хаагчийн хувь | 16% | 1% хүртэл нэмэгдүүлнэ | Ажлын байрны сургалтад давхардсан тоогоор 5170, зайн буюу телемедицины сургалтад давхардсан тоогоор 862 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан. | 100 |
| | | | Гадаад сургалтад хамрагдсан албан хаагчийн хувь | 7% | 1% хүртэл нэмэгдүүлнэ | Эрүүл мэндийн ажилтныг гадаад сургалтад хамруулахаар төлөвлөсний дагуу нийт 7 удаагийн Эрүүл мэндийн хөгжлийн төв, Эрүүл мэндийн яамнаас зохион байгуулсан сургалтад хуваарийн дагуу БНХАУ-ын Хөх хот, Тайвань, БНСУ, Сингапурт нийт 29 их эмч, эмнэлгийн мэргэжилтэнг гадаад сургалтад хамруулсан байна | 100 |
| | | | Сургалтад хамрагдсан удирдах ажилтаны хувь | 50% | 1% хүртэл нэмэгдүүлнэ | Эрүүл мэндийн салбарын удирдах ажилтнуудыг чадавхжуулах ажлын хүрээнд Сумын эмч мэргэжилтнүүдийн холбоотой хамтран Улаанбаатар хотод “Сумын эрүүл мэндийн төвийн удирдлагын хөгжил” сэдэвт сургалтад Орхон, Дулаанхаан, Ерөө, Шаамар, Сант, Хушаат, Баянгол, Цагааннуур зэрэг нийт 8 сумын эрүүл мэндийн төвийн даргыг хамруулсан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | болон эрүүл мэндийн удирдах ажилтнуудыг үе шаттайгаар бэлтгэн ур чадварыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. | | | | | ”Эрүүл мэндийн салбарын авлигын эсрэг 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-ны хэрэгжилтийг ханган ажиллах ажлын хүрээнд Авлигатай тэмцэх газар, Аймгийн Засаг даргын тамгын газартай хамтран Авлигын эсрэг хуулийн хориглолт, хязгаарлалт, хэрэгжилтийн талаарх цахим сургалтыг зохион байгуулж нэгдсэн эмнэлгүүд, сум, тосгоны эрүүл мэндийн төвүүдийн дарга, санхүүгийн албаны холбогдох албан тушаалтан нийт 28 нэгжээс 186 хүнийг хамруулсан. | |
| 1.1.4 | Аймгийн нэгдсэн эмнэлгийг ерөнхий мэргэшил судлалаар сургалт эрхлэх байгууллага болгон бэлтгэж, шаардлагатай хөрөнгө оруулалтыг шийдвэрлэж, орон нутгийн эрүүл мэндийн байгууллагад шаардлагатай | Улсын төсөв | Сургалт эрхлэх байгууллагын тоо | - | 1 | Эрүүл мэндийн сайд Аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний дагуу 2025 ондоо Эмнэлгийн мэргэжилтэн ажиллан суралцах журмын дагуу Аймгийн нэгдсэн эмнэлгийг сургалт эрхлэх байгууллага болгох зорилтыг тавин Эрүүл мэндийн хөгжлийн төвтэй хамтран эмнэлзүйн сургагч багшийг бэлтгэх улмаар шалгуур үзүүлэлтийн дагуу суралцагчийн нийгмийн баталгааг хангах амьдрах байр, суралцах орчныг бүрдүүлэн 17 шалгуур үзүүлэлтийн дагуу төлөвлөгөө гарган төлөвлөгөөний дагуу Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс ажлын хэсэг ирж эхний шатны үнэлгээг хийн ажилласан байна. Энэ ажлын хүрээнд Эрүүл мэндийн хөгжлийн төвтэй цахим уулзалтыг 3 удаа зохион байгуулж ерөнхий мэргэшил судлалаар орон нутагт суралцахаар ирэх эмчийг амьдруулах нийгмийн баталгааг хангахаар аймгийн нэгдсэн эмнэлгийн уламжлалтын тасгийн 600м кв блокийг засварлан 30 эмч амьдрах байр, сургалт явагдах эмнэлзүйн өрөөг тохижуулсан. | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хүний нөөцийг мэргэшүүлэн бэлтгэх арга хэмжээг хамтран хэрэгжүүлж, дэмжлэг үзүүлнэ. | | Бэлтгэгдсэн сургагч багшийн тоо | 2 | 3 | Аймгийн нэгдсэн эмнэлгийг сургалт эрхлэх байгууллага болгох зорилтын хүрээнд бэлтгэгдсэн эмнэлзүйн сургагч багш 7 байна. Сургагч багшийг орон нутагт бэлтгэх зорилгоор Эрүүл мэндийн хөгжлийн төвд хүсэлт тавьж нийт 25 эмч эмнэлгийн мэргэжилтэнг бэлтгэхээр ажиллаж байна. | 100 |
| 1.1.5 | Эмч, эмнэлгийн мэргэжилтэн төгсөлтийн дараах үндсэн болон төрөлжсөн мэргэшил олгох сургалтад хамруулна | Улс, орон нутаг төсөв | Мэргэшүүлэх сургалтад хамрагдсан эмч, эмнэлгийн мэргэжилтний тоо | 7 | 8 | Үндсэн болон төрөлжсөн, дээшлүүлэх сургалтад нийт 29 их эмч, сувилахуйн мэргэшлийн төрөлжсөн, дээшлүүлэх сургалтад нийт 12 сувилагч тусгай мэргэжилтэн, нийт улсын төсвийн санхүүжилтээр 41 эмч, эмнэлгийн мэргэжилтэн 2025 онд суралцаж байна. | 100 |
| **2. "Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, эмийн зохистой хэрэглээ, хангамж нөөцийг бүрдүүлэх чиглэлд"** | | | | | | | |
| 1.2.1 | Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх чиглэлээр эмнэлгийн ажилчид болон | Улс, орон нутаг төсөв | -Эмнэлгийн ажилчдад чиглэн зохион байгуулагдсан сургалтын тоо | - Эмнэлгийн ажилчдад 18 сургалт | Эмнэлгийн ажилчдад чиглэн зохион байгуулагдсан сургалт 20<br>Иргэдийн дунд 40 | Эмнэлгийн ажилчдад чиглэн зохион байгуулагдсан сургалтын тоо - 19<br><br>Анхан шатны өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн дарга нар болон мэргэжилтнүүдийг хамруулсан сургалтад 265 хүнийг хамруулсан.<br><br>Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх чиглэлээр иргэдийн **дунд** зохион | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | иргэдэд сургалт зохион байгуулах | | -Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх чиглэлээр иргэдийн дунд зохион байгуулагдсан сургалтын тоо | -Иргэдэд чиглэсэн сургалт 35 | сургалтыг зохион байгуулна. Цахим хэлбэрээр 24 удаа хүргэнэ. | байгуулагдсан сургалтын тоо 8 нийт 251 иргэн хамрагдсан байна. | |
| 1.2.2 | Эм, эмнэлгийн хэрэгслийн хангамж, хүртээмж, нөөцийг нэмэгдүүлэн бүртгэл, хяналтын цахим тогтолцоог бүрдүүлэх | Улс, орон нутаг төсөв | -3 сарын нөөц бүрдүүлсэн эмийн сангийн тоо<br>-Цахим бүртгэлд хамрагдсан эмийн сангийн тоо<br>-Зайлшгүй шаардлагатай эмийн хангалтын хувь | -3 сарын нөөц бүрдсэн 20<br>-Цахим бүртгэлд хамрагдсан 45<br>-Зайлшгүй шаардлагата | -3 сарын нөөц бүрдсэн 21<br>-Цахим бүртгэлд хамрагдсан эмийн сангийн тоог 48<br>-Зайлшгүй шаардлагатай эмийн хангалтын 98-аас доошгүй байлгана | Эм, эмнэлгийн хэрэгслийн хангамж, хүртээмжийг 3 сарын нөөцөөр бүрдүүлсэн.<br>Цахим бүртгэлд хамрагдсан эмийн сангийн тоог 54 болгон, гурвалсан гэрээгээр энгийн эмийн жорын цахимаар бичдэг болсон.<br>Зайлшгүй шаардлагатай эмийн хангалтын хувь 98,3 хувьтай байна.<br>Эрүүл мэндийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 20-ний өдөр батлагдсан А/521 “Эмийн жор цахимаар бичих, олгох түр заавар батлах тухай ” тушаалын хэрэгжилтийг хангах зорилгоор нийт 17 сум 6 тосгон 2 нэгдсэн эмнэлгийн нийт 270-н эмч, эмнэлгийн мэргэжилтэнд сургалт орсон. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | й эмийн хангалт 98 хувь | | | |
| 1.2.3 | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 36.1.2-т заасны дагуу Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх | Улс, орон нутаг төсөв | -Зайлшгүй шаардлагатай эмийн хангалтын хувь | 90% | 90% | Эрүүл мэндийн салбарт 2025 онд хэрэглэгдэх эм эмнэлгийн хэрэгслийн тендерийг Эрүүл мэндийн газрын даргын А/04 тушаалаар тендерийн хороо байгуулагдан, Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа жил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу СЭАЭМГ/20250102002 дугаартай тендер зарлагдан 10 эм ханган нийлүүлэх байгууллага санал ирүүлж 10 байгууллагатай гэрээ байгуулан эм эмнэлгийн хэрэгслийг ханган ажиллаж байна.<br><br>2025 онд шалгарсан компаниудаас хямд үнэтэй, чанарын баталгаатай, эм, эмнэлгийн хэрэгслийг авч, улирал тутам тогтмол нийлүүлэгдэж байгаагийн үр дүнд эм, эмнэлгийн хэрэглэлийн хүртээмж нэмэгдэж зайлшгүй шаардлагатай эмийн хангалт 2 сарын нөөцтэйгөөр 97%-д хүрсэн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тусламж үйлчилгээнд хэрэглэх эм, эмнэлгийн хэрэгслийн тооцоо судалгааг гаргаж худалдан авах ажиллагааг зохион байгуулна | | -Эм эмнэлгийн хэрэгсэл худалдан авах ажиллагаа зарласан тоо | 5 | 5 | Орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хуулийн дагуу Сум тосгоны ЭМТ-н эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах (СЭАЭМГ/20250102002) Нээлттэй тендерийг байгууллагын даргын 2025-01-30 ны А/03 тушаалаар Тендерийн бичиг баримтыг шалгуур үзүүлэлтийн дагуу Tender.gov.mn цахим системд 2025-02-11, 2025-04-23, 2025-06-19, 2025-08-05, 2025-10-09 -ны өдөр нийт 5 удаа нийтэлсэн. Эм, эмнэлгийн хэрэгслийн захиалгын төсөв 330 сая төгрөг 38 багц. Үүнээс 28 багцын , 264.0 сая төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авах гэрээг 10 байгууллагатай хийсэн байна. 2025 оны тендерийн багцын захиалга 80 % байна. | 90 |
| **Зорилт-3:Эрүүл мэндийн салбарын барилга, байгууламж, автомашин, багаж тоног, төхөөрөмжийн засвар, үйлчилгээ, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх** | | | | | | | |
| 1.3.1 | Эрүүл мэндийн салбарын шинэ барилга, барилга байгууламжийн засвар үйлчилгээний шинэчлэлтийн ажил хийх | Улс, орон нутаг төсөв | Засвар үйлчилгээ хийгдсэн барилгын тоо | 2 | 2 | Хушаат сумын эрүүл мэндийн төвд эргэлтийн эмийн сан байгуулах ажлыг орон нутгийн 99.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 2024оны 1 сард тендер зарлаж "Сэлэнгэ ундраг" ХХК гүйцэтгэгчээр шалгарч 2025оны 5 сарын 25-нд бүрэн дуусаж хүлээлгэн өгсөн.<br>Мандал суман дахь Нэгдсэн эмнэлгийн дотор их засварыг орон нутгийн хөрөнгө оруулалтаар 297,1сая төгрөгийн тендер зарлаж "Ок вууд" ХХК гүйцэтгэгчээр шалгарч 2025оны 12 сарын 8нд бүрэн дуусаж хүлээлгэн өгсөн. | 100 |
| | | | Өргөтгөл хийгдсэн барилгын тоо | 1 | 1 | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Эрүүл мэндийн яамнаас тендерийг зарлан Нано констракшин ХХК шалгарч, эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилгын гүйцэтгэл байдлаар 90%-тай. | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.3.2 | Эрүүл мэндийн салбарын түргэн тусламжийн автомашины парк шинэчлэлтийг нэмэгдүүлэх | Улс, орон нутаг | Түргэн тусламжийн автомашин парк шинэчлэлт хийгдсэн тоо | 10 | 6 | Орон нутгийн хөрөнгө оруулалтаар Мандал сумын өрхийн эмнэлгүүдэд 3 ширхэг Prius 41, Цагааннуур, Жавхлант эрүүл мэндийн төвүүдэд Toyota prius-30 маркийн автомашин бүрэн хүлээлгэн өгсөн | 90 |
| 1.3.3 | Эрүүл мэндийн байгууллагуудыг шаардлагатай багаж, тоног төхөөрөмжөөр хангах ажлыг үе шаттайгаар зохион байгуулах | Улс, орон нутаг төсөв | Тоног төхөөрөмжийн насжилтын хувь | 40% | 43% | Нэгдсэн эмнэлгийн хүүхдийн эрчимт эмчилгээний тасагт 49,8сая төгрөгийн 13 нэр төрлийн тоног төхөөрөмж,Түшиг сумын эрүүл мэндийн төв шүдний кабинетын тоног төхөөрөмжөөр тус тус хангагдсан. | 100 |
| | | | Тоног төхөөрөмжийн хангалтын хувь | 80% | 83% | Нэгдсэн эмнэлгийн хүүхдийн эрчимт эмчилгээний тасагт 49,8сая төгрөгийн 13 нэр төрлийн тоног төхөөрөмж,Түшиг сумын эрүүл мэндийн төв шүдний кабинетын тоног төхөөрөмжөөр хангаж тоног төхөөрөмжийн хангалт 81.2%-тай байна. | 100 |
| **Зорилт-4:Үйл ажиллагааны гүйцэтгэлд суурилсан, үр дүн, үр ашигт чиглэсэн санхүүжилтийг нэвтрүүлэх, сахилга хариуцлагыг дээшлүүлэх, тайлагналыг оновчтой болгох** | | | | | | | |
| 1.4.1 | Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, иргэнийг дагасан гүйцэтгэлийн санхүүжилтийг бүрэн авч ажиллах | Гүйцэтгэлийн санхүүжилт | Нийгмийн даатгалын гүйцэтгэлийн санхүүжилт авсан хувь | 86% | 1,5% хүртэл нэмэгдүүлнэ | Анхан болон лавлагаа шатлалын эмнэлэг ЭМДЕГ-с санхүүжсэн гүйцэтгэлийн санхүүжилт 90 % тай байна. | 90 |
| 1.4.2 | Санхүүгийн хяналт хийж үр | Улс, орон | Санхүүгийн хяналт | 4 | 6 | Сар бүрийн 1 нд (амралт баярын өдөр таарвал ажлын эхний өдөр) 2 нэгдсэн эмнэлэг, 17 сум, 6 тосгоноос | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | дүнг тооцож ажиллах | нутаг төсөв | хийгдсэн ЭМБ-н тоо | | | Төсвийн гүйцэтгэлийн мэдээг авч нэгтгэн хянан баталгаажуулан сангийн яаманд хүргүүлэн, өглөг авлагын мэдээг нэгтгэн шаардлагатай тохиолдолд ЭМЯ-нд хүргүүлж, Эрүүл мэндийн яамнаас өгсөн 2025 оны санхүүгийн жилд ажиллах чиглэлийг цахимаар болон албан бичгээр хүргүүлэв. Баруунбүрэн, Рашаант тосгоны эрүүл мэндийн төвд ажлын байран дээр хяналт шалгалтыг хийж зөвлөмж өгөв. Мөн АНЭ-т Цалин шимтгэл, эмийн өрийн асуудлаар хяналт хийж зөвлөмжийг хүргүүлэв. | |
| **Зорилт-5: Архив бичиг хэрэг хөтлөлтийг сайжруулах ажлын хүрээнд** | | | | | | | |
| 1.5.1 | Архивын сан хөмрөгийн бүрдүүлэлт, баримтад цахим архив үүсгэх, цахим мэдээллийн аюулгүй байдал, нууцлалыг хангаж ажиллана | | Байгууллагын архивын баримтыг цахимд шилжүүлсэн хувь | 50% | 60% | Аймгийн Засаг даргын 2025 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн "Дэд комисс томилж, үзлэгийн хуваарь батлах тухай" А/426 дугаар захирамжийн дагуу архивын улсын үзлэгийн мөрөөр хэрэгжүүлэн үйл ажиллагаа Сайн үнэлгээ авч ажилласан.<br>Төрийн архивын хэлтэст Эрүүл мэндийн газрын даргын 2010-2016 оны 34 баримт бичгийг хүлээлгэн өгч ажилласан. Байгууллагын архивын баримтыг цахимд 100 хувь бүрэн шилжүүлсэн. | 100 |
| | | | Баримтын нууцлалын хувь | 100% | 100% | Байгууллагын 1999-2016 он хүртэлх байнга хадгалах хадгаламжийн нэгжийг цахим хэлбэрт шилжүүлэн шинээр архивын компьютерт нууцлалын хانган ажиллаж байна. | 100 |
| **Хоёр."Эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, арга зүйн дэмжлэг үзүүлэх, хяналт тавих** | | | | | | | |
| **Зорилт 1 Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй холбоотой харилцаа, үйл ажиллагааны чиглэлээр мэргэжил аргазүйн удирдлагаар хангах** | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.1.1 | Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг хүн амын эрэлт хэрэгцээ салбарын бодлогод нийцүүлэн Эрүүл мэндийн газрын даргаар ахлуулсан тусгай зөвшөөрөл олгох комиссын үйл ажиллагааг зохион байгуулж ажиллана | Улсын төсөв | Тусгай зөвшөөрлийн сунгалтын материал ирүүлсэн ЭМБ-ын тоо | 24 | 24 | Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Зөвшөөрлийн тухай хуулийн 5.2, 5.4, Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх заалтуудын дагуу Сэлэнгэ аймагт эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын хурлыг 2025 онд нийт 7 удаа зохион байгуулж 42 байгууллагын хүсэлтийг хэлэлцэн, дүгнэлт гаргаж ажилласан. Үүнд:<br>Тусгай зөвшөөрөл шинээр олгосон – 8<br>Тусгай зөвшөөрөл сунгасан - 27<br>Гэрчилгээ шинэчилсэн -1<br>Хуулийн этгээдийн нэр өөрчилсөн – 1<br>Хаягийн өөрчлөлт хийгдсэн – 1<br>Түдгэлзүүлсэн – 1<br>Хүчингүй болгосон – 2<br>Буцаасан – 1 эрүүл мэндийн байгууллага байна. | 100 |
| | | | Сунгалтын материалыг шийдвэрлэсэн хувь | 100% | Тухай бүр | Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Зөвшөөрлийн тухай хуулийн 5.2, 5.4, Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх заалтуудын дагуу Сэлэнгэ аймагт эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын хурлыг 2025 онд нийт 7 удаа зохион байгуулж 42 байгууллагын хүсэлтийг хэлэлцэн, дүгнэлт гаргаж ажилласан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Шинжээчдийн багийн хяналт үнэлгээнд хамрагдсан ЭМБ-ын тоо | 5 | 10 | Тусгай зөвшөөрлийн комиссын даргын удирдамжийн дагуу Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх 4 эмийн сан, 1 хорих анги байгууллагийн эрүүл мэндийн төв, 1 шүдний эмнэлэг, 1 лаборатори нийт 7 байгууллагад газар дээр нь хяналт, үнэлгээг хийж 5 байгууллага бага эрсдэлтэй үнэлэгдэж эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгож, 1 байгууллагад хаягийн өөрчлөлт хийж, 1 байгууллагыг буцаасан байна. | 100 |
| **Зорилт 2.“Цахим Монгол” арга хэмжээний хүрээнд эрүүл мэндийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж, орон нутагт хийгдэх оношилгоо, эмчилгээнд алсын зайн технологи ашиглан, цахим эрт илрүүлэг, эргэн дуудах тогтолцоог бүрдүүлнэ** | | | | | | | |
| 2.2.1 | Эрүүл мэндийн байгууллагад мэдээлэл, технологийн техник хангамж, сүлжээ, программ хангамжийн дэд бүтцийг өргөжүүлэн бүх эрүүл мэндийн байгууллагыг өндөр хурдны интернэт сүлжээнд | Улс, орон нутгийн төсөв | Интернэтийн хурдаа нэмэгдүүлсэн эрүүл мэндийн байгууллагын хувь | 98% | 98.5% | Аймгийн хэмжээнд 28 эрүүл мэндийн байгууллага интернэт сүлжээгээр хангагч байгууллагатай гэрээ байгуулан өндөр хурдны интернэт сүлжээнд бүрэн холбогдсон. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | холбогдоход дэмжлэг үзүүлэх, арга зүйгээр хангах | | | | | | |
| 2.2.2 | Анхан болон лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагууд алсын зайн анагаах ухаан /телемедицин/ ашиглах боломжийг бүрдүүлэн техник тонон төхөөрөмжөөр хангах | Улс, орон нутгийн төсөв | Телемидицинийг тусламж үйлчилгээнд нэвтрүүлсэн эрүүл мэндийн байгууллагын тоо | 2 | 6 | Аймгийн нэгдсэн эмнэлэг Мандал сумын нэгдсэн эмнэлэг нь алсын зайн анагаах ухаан телемедцины үйлчилгээг лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагуудтай 10 удаа холбогдож эрүүл мэндийн тусламж үйлчилгээг цахимаар авсан. Тусламж үйлчилгээг авах явцад өндөр хурдны интернэтээр бүрэн хангагдаж интернэтийн тасалдал үүсээгүй тусламж үйлчилгээг үзүүлэн ажилласан. Энэ жил нэмэлтээр алсын зайн анагаах ухаан телемедцины үйлчилгээг нэвтрүүлээгүй болно. | 100 |
| 2.2.3 | Эрүүл мэндийн байгууллага нь онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллага гэж Кибер аюулгүй байдлын тухай | Улс, орон нутгийн төсөв | Шаардлагатай сервер, тоног төхөөрөмжөөр хангагдсан хувь | 30% | 40% | Аймгийн нэгдсэн эмнэлэг болон Мандал сумын нэгдсэн эмнэлэг нь Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 19.1.3 дахь заасны дагуу эрүүл мэндийн мэдээллийн аюулгүй байдал, мэдээллийн системийн өдөр тутмын үйл ажиллагааг явуулахад шаардлагатай сервер, тоног төхөөрөмжөөр хангаж мэргэжлийн IT инженер хяналт тавьж системийн аюулгүй байдлыг хангаж ажиллаж байна. Одоогоор системд бүртгэгдсэн зөрчил халдлага бүртгэгдээгүй байна. Эрсдэлийн үнэлгээг хийлгэхээр | 70 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | хуулийн 19.1.3 дахь заасны дагуу эрүүл мэндийн мэдээллийн аюулгүй байдал, мэдээллийн системийн өдөр тутмын үйл ажиллагааг явуулахад шаардлагатай сервер, тоног төхөөрөмжөөр ханган байнгын хяналт тавьж эрсдэлийн үнэлгээг хийлгэж зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана. | | | | Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Кибер аюулгүй байдлын бодлого зохицуулалтын газарт хүсэлтээ илгээгээд байна. | |
| **Гурав 3. Эрүүл мэндийн байгууллагуудын тусламж үйлчилгээний чанар хүртээмжийн байдалд дэмжлэгт хяналт үнэлгээ хийх мэргэжил аргазүйн зөвлөмжөөр хангах** | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.1 | Тусламж үйлчилгээний чанар хүртээмжийн байдалд дэмжлэгт хяналт хийх | Байгууллагын төсөв | Хяналт үнэлгээнд хамрагдсан байгууллагуудын тоо | 10 | 11 | 2025 оны байдлаар нийт 19 эрүүл мэндийн байгууллагын 9 сумын эрүүл мэндийн төв, 3 тосгоны эрүүл мэндийн төв, 5 өрхийн эрүүл мэндийн төв, 2 хувийн хэвшлийн эмнэлгүүдэд тусламж үйлчилгээний чанар хүртээмж, бэлэн байдалд дэмжлэгт хяналтыг зохион байгуулан ажилласан. | 100 |
| | | | Хүргүүлсэн зөвлөмжийн тоо | 19 | Тухай бүрд нь | Дэмжлэгт хяналт үнэлгээгээр гарсан дүгнэлтийн дагуу дээрх 19 эрүүл мэндийн байгууллагуудад үйл ажиллагаануудыг сайжруулах, хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор зөвлөмжийг хүргүүлэн, хяналт тавин ажилласан. | 100 |
| **3.2. Эх, хүүхдийн эрүүл мэндийг дэмжиж, өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлж, орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг өргөжүүлж, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.** | | | | | | | |
| 3.2.1 | Шүдний кабинеттай анхан шатны эрүүл мэндийн байгууллагууд хүүхдийн амны хөндийн эрүүл мэндийг дэмжих, шүд цоорох өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоог | Улс, орон нутгийн төсөв | -Эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан хүүхдийн тоо | 30000 | 31000 | Эрүүл шүд арга хэмжээний (2024-2027) төлөвлөгөөний хүрээнд иргэдэд хүртээмжтэй эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэх зорилгоор Алтанбулаг, Баянгол, Цагааннуур, Шаамар, Ерөө, Сайхан, Зүүнбүрэн, Жавхлант, Орхонтуул, Баруунбүрэн, Түшиг сум, Хэрх, Түнхэл тосгоны эрүүл мэндийн төвүүдэд шүдний кабинетыг байгуулан ажиллаж байна. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын шүдний кабинет 2025 оны 11 дүгээр сарын нийт үзлэг 9374 байна. Үүнээс эрэгтэй 4287, эмэгтэй 5087, 0-17 насны 8747 хүүхэд үзлэг эмчилгээнд хамрагдсан. Нийт эмчилгээ 11142, шүд авалт 1597, түрхлэг 1545, сувгийн эмчилгээ 4293, бүрэн эрүүлжсэн 3263, урьдчилан сэргийлэх үзлэг, зөвлөгөө авсан 9589 иргэн хамрагдсан байна. | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | зохион байгуулж эрүүлжилтийн ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ. | | -Өвчтэй илэрсэн хүүхдүүдийг эмчилгээнд хамруулж эрүүлжүүлсэн хувь | 30% | 35% | Шүдний үзлэг оношилгоонд хамрагдсан хүүхдүүдээс өвчтэй илэрсэн 8747 хүүхдийн 3263 буюу 37.3 хувийг бүрэн эрүүлжүүлээд байна. | 90 |
| 3.2.2 | “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн орон тооны бус зөвлөл”-ийг орон нутгийн түвшинд төлөвлөгөө боловсруулан, хэрэгжилтэд үр дүн тооцох | Улс, орон нутгийн төсөв | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | - | 50% | Аймгийн Засаг даргын 2024 оны А/487 “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн орон тооны бус зөвлөл байгуулах тухай” захирамжийн дагуу салбар дундын хамтын ажиллагааг сайжруулахаар 2025 онд хийх ажлын төлөвлөгөөг сумын Засаг дарга, тосгоны захирагч, өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн дарга нарт хүргүүлэн, хэрэгжилтийг ханган үр дүн тооцохоор бүх шатны эрүүл мэндийн байгууллагаас тайлан мэдээг авч, үр дүн тооцон ажиллаж байна. | 90 |
| 3.2.3 | Өрх, сум, тосгодын эрүүл мэндийн төвд 9, 18, 36 сартай хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэгийг зохион байгуулж, | Улс, орон нутгийн төсөв | 9, 18, 36 сартай хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэгт хамруулсан хүүхдийн тоо | 506 | 800 | Аймгийн хэмжээнд 2025 оны байдлаар 9, 18, 36 сартай хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэгт хамруулсан нийт хүүхдийн тоо 2467, үүнээс хөгжлийн хоцрогдол болон суурь өвчтэй 140 хүүхдийг илрүүлж ажилласан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хамрагдалтыг нэмэгдүүлэх | | Дараагийн шатлалд шилжүүлсэн хүүхдийн тоо | 182 | тухай бүр төрөлжсөн мэргэжлийн багт шилжүүлж ажиллана. | 9, 18, 36 сартай хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэгт нийт 2467 хүүхдийг хамруулсан бөгөөд хөгжлийн хоцрогдол болоод суурь өвчтэй 140 хүүхэд илэрснээс 4 хүүхдийг лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагад шилжүүлэн ажилласан. | 100 |
| **3.3 “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдэд үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулж, эх, нялхас, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, ялангуяа сэргийлж болох эндэгдлийг тууштай бууруулах”** | | | | | | | |
| 3.3.1 | Жирэмсний эрт үеийн хяналтын хамралтыг нэмэгдүүлэх, жирэмсэн үед илэрсэн өвчин эмгэгийг эмчлэх | Улс, орон нутгийн төсөв | 1.Жирэмсний эрт үеийн хяналтын хувь | 89,6% | 90% | Сэлэнгэ аймагт 2025 оны эхний 11 сарын байдлаар шинээр 1194 жирэмсэн хяналтад орсны 91,7 хувийг жирэмсний эхний 3 сарын дотор хяналтанд авсан байна.<br><br>Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/760 дугаар тушаалаар баталсан “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтэд төгсгөлийн үнэлгээ хийх, ололт амжилт, сургамжид дүн шинжилгээ хийж, төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд тулгарсан саад бэрхшээлүүдийг тодорхойлж, цаашид эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах чиглэлээр арга хэмжээний санал, зөвлөмж боловсруулах, зөвлөгөө өгөх зорилготой Эрүүл мэндийн яам, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Тандалт судалгааны албаны ажлын хэсэг манай аймагт 01 дүгээр сарын 16, 17-ны өдрүүдэд Эрүүл мэндийн газар, аймгийн Нэгдсэн, Эмнэх баг өрхийн эрүүл мэндийн төв, Шаамар сумын эрүүл мэндийн төвд тус тус ажилласан.<br><br>Монгол Улсын Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/292 дугаар “Жирэмсэн, төрөх, төрсний дараах үед үзүүлэх тусламж, үйлчилгээний журам”-ын хэрэгжилтийг | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | эрчимжүүлэх, эх барихын тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, эхийн эндэгдэл, ноцтой хүндрэлээс сэргийлэх зорилгоор "Монголын Эх Барих Эмэгтэйчүүдийн Эмч Нарын Холбоо" төрийн бус байгууллагатай хамтран "Жирэмслэхээс өмнөх болон жирэмсэн үеийн тусламж үйлчилгээ" сэдэвт онол дадлага хосолсон сургалтыг эх барих, эмэгтэйчүүдийн эмч, эх баригч, өрх, сум, тосгоны эмч нарт зохион байгуулж, нийт 62 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдлаа.<br><br>ЭХЭМҮТ, АШУҮИС-ын сувилахуйн сургуультай хамтран бүх шатны эрүүл мэндийн байгууллагын эх баригч бага эмч нарыг чадавхжуулах "ЭХ БАРИХЫН ЯАРАЛТАЙ ТУСЛАМЖ" сургалтад нийт 34 эх баригч нарыг хамруулсан. Тус сургалтаар эх баригчийн үзүүлэх яаралтай тусламжийн менежмент, сургалтын хөтөлбөр, албан тушаалын тодорхойлолт, жирэмсний хяналт сэдвээр мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. | |
| | | | 2.Жирэмсэн үеийн гурвалсан халдварын илрүүлэг шинжилгээнд хамрагдсан хувь | 95% | 96% | Нийт жирэмсний хяналтад орсон эмэгтэйчүүдийг 99,5 хувь цусны шинжилгээнд, тэмбүү 99.8%, ДОХ 99.8%, трихомониаз 81.2%, заг хүйтэн илрүүлэх шинжилгээнд 78.7%-ийг тус тус хамруулсан байна. Үүнээс анхан болон давтан шинжилгээгээр цус багадалттай 10 жирэмсэн, заг хүйтэн 2, трихомониазтай 19, тэмбүүтэй 5 жирэмсэн, хавьтагч нартай нь илрүүлж эмчилснээр төрөлхийн тэмбүүгийн тохиолдол бүртгэгдээгүй. | 100 |
| 3.3.2 | 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн | Улс, орон | | 11,8% | Улс аймгийн дунджаас | 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл улсын хэмжээнд 2025 оны 11 сарын байдлаар 837 тохиолдол бүртгэгдэж 1000 амьд төрөлтөд 16.8 байгаа ба манай аймгийн хувьд 15 тохиолдол бүртгэгдэж 1000 амьд төрөлтөд 16.5 байгаа нь | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | шалтгаанд дүн шинжилгээ хийх, авч хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх | нутгийн төсөв | 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг түвшин /1000 амьд төрөлтөд/ эзлэх хувь | | доогуур байна | өнгөрсөн оны мөн үеэс 3.6 промиллоор өссөн үзүүлэлттэй байна.<br>Тус эндэгдлүүдээс эмнэлэгт эндсэн 6 хүүхдийн тохиолдлыг магадлан хэлэлцэх хурлыг аймгийн Нэгдсэн эмнэлэг, Мандал сумын Нэгдсэн эмнэлэг 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл хэлэлцэх хурлыг холбогдох эмч, эмнэлгийн мэргэжилтэнг хамруулж, эндэгдэлд судалгаа хийж, бууруулах чиглэлээр ажлыг зохион байгуулан ажилласан.<br>Эх Хүүхдийн Эрүүл Мэндийн Үндэсний Төвийн Тандалт Судалгааны Албанаас зохион байгуулдаг "Нярай, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, өнөөгийн байдал" сэдэвт цахим хуралд холбогдох эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг тасралтгүй хамруулж байна.<br>5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг бууруулах зорилгоор Google sheet үүсгэж 9, 18, 36 сартай хүүхдийн хоцрогдлыг үнэлэх сар бүр илгээдэг тайлан, 0-1 насны хүүхэд, 1-5 хүртэлх насны хүүхэд, 6-19 насны хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн судалгааг цахим хэлбэрт шилжүүлэн ажиллаа.<br>Мөн 0-1 насны хүүхдийн гэрийн эргэлтийг цахимаар хянаж ажиллаа. | |
| 3.3.3 | Эхийн эндэгдлийн шалтгаанд дүн шинжилгээ хийх, авч хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх | Улс, орон нутгийн төсөв | Эхийн эндэгдэл 0 промилл /100,000 амьд төрөлтөд/ | 1 эхийн эндэгдлийн түвшин 90.7 | 0 | Улсын хэмжээнд 2025 оны эхний 11 сарын байдлаар эхийн эндэгдлийн 17 тохиолдол бүртгэгдэж, 100.000 амьд төрөлтөд 34.2 ногдож байгаа ба манай аймаг 2025 онд эхийн эндэгдлийн 1 буюу 100.000 амьд төрөлтөд 110.3 ногдож байна. Эхийн эндэгдэл дахин гарахаас сэргийлж эхийн эндэгдэл хэлэлцэх, эмнэлзүйн конференци, зөвлөлийн хурлыг зохион байгуулан, түүний гарсан шийдвэр зөвлөмжийн дагуу эхэд үзүүлэх тусламж, үйлчилгээний 3 зорилт, 14 ажлын төлөвлөгөө | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | боловсруулан, хэрэгжүүлэн ажиллаж, хийсэн ажлын тайланг бүх шатны эрүүл мэндийн байгууллагуудаас авч үр дүн тооцсон.<br><br>Анхан шатны бүх эрүүл мэндийн байгууллагуудад долоо хоног бүрийн 4 дэх өдрийн цаг үеийн мэдээллийн цагаар эхний эндэгдэл, ноцтой хүндрэл, 5 хүртэлх хүүхдийн эндэгдлийн чиглэлээр анхааруулах мэдээллийг цахимаар өгч ажилласан. Мөн Эх Хүүхдийн Эрүүл Мэндийн Үндэсний Төвийн Тандалт Судалгааны Албанаас зохион байгуулдаг “Эхийн эндэгдэл, ноцтой хүндрэл”-ийн цахим хуралд холбогдох эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг тасралтгүй хамруулж байна. | |
| 3.3.4 | Жирэмсэн эмэгтэйн амь насанд ноцтой хүндрэл гарч зайлшгүй тээвэрлэх шаардлага үүссэн тохиолдолд онгоц болон бусад тээврийн хэрэгслийн зардлыг Засаг даргын нөөц хөрөнгөөс | Улс, орон нутгийн төсөв | Жирэмсэн эмэгтэй амь насанд ноцтой хүндрэл гарахаас урьдчилан сэргийлж, үзүүлсэн тусламжийн тоо | 0 | Тохиолдол гарсан үед, яаралтай арга хэмжээ авч шийдвэрлэсэн байна. | Жирэмсэн эмэгтэйн амь насанд ноцтой хүндрэл одоогоор бүртгэгдээгүй байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | гаргуулан дэмжлэг авах | | | | | | |
| **3.4 ЭМНЭЛГИЙН АНХАН БОЛОН ЛАВЛАГАА ШАТЛАЛЫН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ №2.1** | | | | | | | |
| “Өрх сумын эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлэгт үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээг өргөжүүлэх, хүртээмжийг нэмэгдүүлэх замаар иргэдийн чирэгдлийг багасгах” | | | | | | | |
| 3.4.1 | Өрхийн эмнэлгүүдтэй хамтран ажиллах гурвалсан гэрээ байгуулж, биелэлтэд хяналт тавьж ажиллах | орон нутгийн төсөв | Гэрээний биелэлтийг дүгнэсэн хувь | 89,7 | Гэрээний биелэлтийг 90%-аас дээш байна. | Эрүүл мэндийн сайдын 2024 оны 03 сарын 15-ний А/122 дугаар тушаалаар батлагдсан шинэчлэгдсэн журмын дагуу “Өрхийн эрүүл мэндийн төвтэй гэрээ байгуулах, хэрэгжилтийг дүгнэх, хяналт тавих, гэрээг сунгах, дуусгавар болгох” тушаалын дагуу 2025 оны хагас жилийн байдлаар аймгийн Засаг даргын захирамжаар баталсан ажлын хэсгийн гишүүд хяналт, үнэлгээг 07 дугаар сард бичмэл тайлан дээр үндэслэн үнэлгээ хийж, 5 өрхийн эрүүл мэндийн төвүүд хангалттай үнэлэгдсэн байна.<br><br>2025 оны жилийн эцсийн гэрээний үнэлгээг 12 дугаар сарын сүүлээр хийхээр бэлтгэл хангган ажиллаж байна. | 100 |
| 3.4.2 | Алслагдсан орон нутгийн хүн ам, түр оршин суугч, явуулын иргэдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг чирэгдэлгүй, | Улс, орон нутгийн төсөв | “Явуулын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ”-г зохион байгуулж, хамруулсан иргэдийн тоо. | 2200 | Өвөлжилт хүндэрсэн газар Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тухай бүрд зохион байгуулж | Эрүүл мэндийн үзлэгт хамрагдаж чаддаггүй алслагдсан, хөдөлгөөнт ба эмзэг бүлгийн хүн амд анхан шатны тусламж үйлчилгээг мобайл технологийг ашиглан халдварт болон халдварт бус өвчний эрт илрүүлэг оношилгоог хийх зорилгоор 2025 онд 15 сум, 6 тосгон, 5 өрхийн эрүүл мэндийн төвд мобайл тусламж, үйлчилгээг зөөврийн ЭХО аппарат болон зүрхний ЭКГ, явуулын дархлаажуулалт, элэгний В, С болон түргэвчилсэн оношлуур, уушгины үйл ажиллагааг хэмжигч спирометр | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хүртээмжтэй хүргэх зорилгоор “Явуулын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ”-г зохион байгуулна. | | | | ажилласан байна. | зэрэг багажийн тусламжтай тусламж үйлчилгээг аймгийн хэмжээнд нийт 39 өрх, 560 хүнд хүрч үйлчилсэн байна.<br><br>Одоогоо зудын эрсдэл үүсээгүй байгаа тул Эрүүл мэндийн газрын даргын баталсан 2025-2026 оны өвөлжилтийн бэлэн байдлын төлөвлөгөөний дагуу өвөлжилт хүндэрсэн газруудад явуулын тусламж үйлчилгээг үзүүлэх багыг томилгоожуулж бэлэн байдлыг хангаж ажиллаж байна. | |
| 3.4.3 | Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд “Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага” MNS 7014:2023 стандартыг эрүүл мэндийн байгууллага бүрд хэвшүүлэх, сурталчлах арга хэмжээ хэрэгжүүлэн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана. | Улс, орон нутгийн төсөв | “Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага” MNS 7014:2023 стандартыг хэрэгжүүлсэн эрүүл мэндийн байгууллагын тоо | 9 | 15 | “Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих MNS 7014:2023 стандарт”-ын сургалтыг танилцуулах, сурталчлах, стандартын хэрэгжилтийг хангах зорилгоор мэдлэг олгох сургалтыг Эрүүл мэндийн салбарын 17 сум 6 тосгоны эрүүл мэндийн байгууллагын чанарын багийн гишүүд болон аймгийн Нэгдсэн эмнэлэг, Мандал сумын Нэгдсэн эмнэлгийн чанарын баг, тасгийн эрхлэгч, амбулаторийн эмч эмнэлгийн мэргэжилтнүүдийн дунд 7 удаагийн сургалтыг зохион байгуулан хяналт тавьж тайланг хугацаанд нь авч стандартыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Мөн салбарын хэмжээнд долоо хоног бүрийн Пүрэв гарагт цаг үеийн байдалтай холбоотой болон бусад холбогдох мэдээ, мэдээллийг хүргэдэг цахим уулзалтын цагаар, магадлан итгэмжлэлд хамрагдаж байгаа өрх, сум, тосгоны Эрүүл мэндийн төвүүдэд “Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага” MNS 7014:2023 стандартыг мөрдөж ажиллах талаар тогтмол чиглэлийг өгч ажиллаж байна. | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.4.4 | Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах зорилгоор магадлан итгэмжлэлд хамруулах | Улс, орон нутгийн төсөв | Магадлан итгэмжлэлд хамрагдсан байгууллагын тоо | 13 | 15 | 2025 онд магадлан итгэмжлэлийн хугацаа дуусаж байгаа нийт 19 эрүүл мэндийн байгууллагын 9 сумын эрүүл мэндийн төв, 3 тосгоны эрүүл мэндийн төв, 5 өрхийн эрүүл мэндийн төв, 2 хувийн хэвшлийн эмнэлгүүд магадлан итгэмжлэлийн үнэлгээнд хамрагдсан байна. Үүнээс 2 байгууллага буюу 10 хувь нь 3 жилээр, 17 байгууллага буюу 90 хувь нь 2 жилээр тус тус сунгагдсан. Мөн Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 1313 дугаартай албан бичгийн дагуу Магадлан итгэмжлэлийн зөвлөлийн хурлын шийдвэрээр эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэлийн эрх зүйн тогтолцоог эрчимжүүлэх, шилжилтийн үеийн тасралтгүй байдлыг хангах зорилгоор 2026 онд магадлан итгэмжлэлд хамрагдах эрүүл мэндийн байгууллагуудыг Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/452 дугаар тушаалаар магадлан итгэмжлэлийн хугацааг нэг удаа, нэг жилээр сунгаж, үнэлгээнд бүрдүүлэх холбогдох бичиг баримтыг цахим системд оруулж баталгаажуулах юм | 100 |
| 3.4.5 | Анагаах ухаан, эрүүл мэндийн салбарын тусламж, үйлчилгээг хиймэл оюун ухаанд тулгуурлан хөгжүүлж аливаа өвчин | Улс, орон нутгийн төсөв | Хиймэл оюун ухаанд суурилсан цээжний рентген зураг авах оношилгоонд орсон хүний тоо | 4624, | 4800 | Хиймэл оюун ухаан суурилсан сүрьеэгийн эрт илрүүлэг, үзлэг оношилгоог Мандал, Цагааннуур, Зүүнбүрэн, Хушаат, Жавхлант, Хүдэр, Шаамар, Алтанбулаг, Ерөө сум, Түнхэл, Хэрх тосгон, Болдтөмөр Ерөө гол ХХК-ны нийт 4347 иргэнд зохион байгуулан ажилласан.<br>Мөн нүдний эмчийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхээр хиймэл оюун ухаанд суурилсан нүдний өвчнийг оношлох аппаратаар нийт 230 хүн хамрагдаж тусламж үйлчилгээ авсан байна. | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | эмгэгийг эрт илрүүлэх оношилгоо нэвтрүүлэх, эмчилгээний чанар хүртээмж нэмэгдүүлэх | | Хиймэл оюун ухаанд суурилсан умайн хүзүүний хорт хавдрын оношилгоонд орсон хүний тоо | 547 | 600 | Аймгийн Нэгдсэн эмнэлгийн Эмэгтэйчүүдийн зөвлөгөө өгөх кабинетэд хиймэл оюун ухаанд суурилсан умайн хүзүүний дурангийн шинжилгээг нийт 1100 хүнд хийж ажилласан байна. | 100 |
| **3.5 Осол гэмтэл, гамшигийн үеийн Эмнэлгийн тусламж үйлчилгээ** | | | | | | | |
| Яаралтай гамшигийн тусламж үйлчилгээний ажлыг эрчимжүүлэх | | | | | | | |
| 3.5.1 | Осол гэмтлээс сэргийлэхэд иргэн бүрийн оролцоо сэдвээр төр болон хувийн хэвшлийн ажилтан албан хаагч, сурагч, оюутан, иргэдэд сургалтыг танхим болон цахим тасралтгүй | Улс, орон нутгийн төсөв | Осол гэмтлийн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээ, үзүүлэх тусламжийн мэдэгдэхүүнтэй болсон хүний тоо | 255 | 5 хувиар нэмэгдүүлнэ | 2025 оны байдлаар Зүүнбүрэн сум, Орхон сумын эрүүл мэндийн төв, төрийн захиргаа болон, төрийн үйлчилгээний албан хаагчдад амилуулах суурь тусламж, хахал, осголт, түлэгдэлтийн үед авах арга хэмжээ сэдэв сургалтыг 100 гаруй төр болон хувийн хэвшлийн ажилчид албан хаагчдад, “Агшин бүрд анхаарал сэрэмжээ нэмж эрсдэлийг бууруулъя” сэдэвт сургалтад Сүхбаатар сумын төр хувийн хэвшлийн 50 гаруй жолооч нар, CU сүлжээ дэлгүүр, Гаалийн газар, Зоонозын өвчин судлал, Цагдаа, Онцгой байдлын газрын нийт 70 гаруй албан хаагч, мэргэжил бүхэн сайхан мэргэжил таниулах сургалтад ирсэн ЕБС-ын 11-12 дугаар ангийн 100 гаруй сурагчдад “Амилуулах суурь тусламж, анхны тусламж”, осол гэмтлийн онол дадлагын сургалтыг тус тус хийж нийт 320 гаруй хүнийг хамруулан ажилласан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | мэдээллээр хангах, | | Цахим мэдээллийг байршуулсан тоо тоо | 4 | 5 | 2025 оны байдлаар олон нийтийн сүлжээ болон эрүүл мэндийн газрын фейсбүүк хаягаар, сумын эрүүл мэндийн төвүүдийн фейсбүүк хаягаар осол гэмтлийн нийт 4 удаагийн хичээлийг оруулж олон нийтэд мэдээллийг хүргүүлсэн. | 100 |
| 3.5.2 | Өвөлжилтийн бэлэн байдлын төлөвлөгөөнд тодотгол хийх | Улс, орон нутгийн төсөв | Өвөлжилтийн бэлэн байдлын төлөвлөгөөнд тодотгол хийсэн тоо, | 1 | 1 | Өвөлжилтийн бэлэн байдлын төлөвлөгөөнд тодотгол хийж, сар бүр отор нүүдлээр явж байгаа иргэдийн судалгаа, эмийн хангалтын судалгаа, малчин иргэд, алслагдсан малчин иргэдийн судалгааг авч нэгтгэн Эрүүл мэндийн яаманд хүргүүлэн ажиллаж байна. | 100 |
| | | | өвөлжилт хүндэрсэн газруудад эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авсан иргэдийн тоо | 2200 | өвөлжилт хүндэрсэн газарт эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүргэж ажилласан байна. | Өвөлжилтийн бэлэн байдлын төлөвлөгөөнд тодотгол хийж, сар бүр отор нүүдлээр явж байгаа иргэдийн судалгаа, эмийн хангалтын судалгаа, малчин иргэд, алслагдсан малчин иргэдийн судалгааг авч нэгтгэн Эрүүл мэндийн яаманд хүргүүлэн ажиллаж байна. | 100 |
| 3.5.3 | Аймгийн хэмжээнд байгаа Хар цэгт ойрхон байрладаг сум, тосгоны эрүүл | Улс, орон нутгийн төсөв | Эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилчдад, сургалт | 1 | 2 | Улсын Нэгдүгээр Төв эмнэлгийн яаралтай тусламжийн тасагтай хамтран Баянгол сумын эрүүл мэндийн төвийн эмч эмнэлгийн ажилчдад сургалтыг орсон мөн Гэмтэл Согог Үндэсний Төвтэй хамтран өрх, сум тосгоны эрүүл мэндийн төв болон Мандал сумын Нэгдсэн эмнэлэг, аймгийн Нэгдсэн эмнэлгийн эмч нарт “Осол гэмтлийн үед | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | мэндийн төвийн эмч, мэргэжилтэн, ажилчдад тогтмол сургалтыг явуулж байх. | | явуулсан тоо. | | | үзүүлэх яаралтай тусламжийн менежмент” сургалтыг зохион байгуулсан.<br>Яаралтай тусламжийн нийгэмлэгээс зохион байгуулсан “Ослын газраас эмнэлэг хүртэлх үеийн тусламж үйлчилгээ” сэдэвт 2 багц цагийн сургалтад Мандал сумын Нэгдсэн эмнэлгийн 1 их эмч, Баянгол сумын Эрүүл мэндийн төвийн 1 их эмчийг хамруулж, мэдлэг ур чадварыг дээшлүүлсэн.<br>“Агшин бүрт анхаарал сэрэмжээ нэмж эрсдэлийг бууруулъя” сэдэвт сургалтад Сүхбаатар сумын төр хувийн хэвшлийн 50 гаруй жолооч нарыг хамруулсан. | |
| | | | Сургалтад хамрагдсан мэргэжилтэний тоо | 21 | 30 | Нэгдсэн эмнэлгийн эмч нарт “Осол гэмтлийн үед үзүүлэх яаралтай тусламжийн менежмент” сургалтыг зохион байгуулж нийт 40 эмч, эмнэлгийн мэргэжилтэн нарыг хамруулсан. | 100 |
| **3.6 СУВИЛАХУЙД ҮЗҮҮЛЭХ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ** | | | | | | | |
| Сувилахуйн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг сайжруулах чиглэлд | | | | | | | |
| 3.6.1 | Сувилахуйн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах, сувилагч эмнэлгийн тусгай мэргэжилтний ур чадварын | Улс, орон нутгийн төсөв | Сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтэн нарт танхим, ажлын байран дээрх сургалт | 70,3 | 75 | Сэлэнгэ аймгийн Засаг даргын дэмжлэгээр Улсын гуравдугаар төв эмнэлэг /УГТЭ/-тэй хамтран ажиллах гэрээний хүрээнд аймгийн Эрүүл мэндийн газраас баталсан удирдамжийн дагуу "Амилуулах лавшруулсан тусламж үйлчилгээг эмнэлзүйн багаар хэрхэн стандарт, удирдамжийн дагуу түргэн шуурхай үзүүлэх, амь тэнссэн яаралтай үе ( blue code)-д багаар ажиллах чадвар, хандлагыг хэрхэн төлөвшүүлж дадлагажуулах зорилго бүхий “Цэнхэр кодоор тусламж үзүүлэхэд эмнэлгийн мэргэжилтний оролцоо” сэдэвт ажил мэргэжлийн ур чадварын тэмцээнийг зохион байгуулсан. Тус тэмцээнд | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тэмцээнийг зохион байгуулах, дэмжлэг хяналт хийж ажиллах | | зохион байгуулсан тоо | | | багийн ахлагч эмч, бага эмч, эх баригч, 2 сувилагч гэсэн 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр аймгийн Нэгдсэн эмнэлэг, Мандал сумын Нэгдсэн эмнэлэг, Сайхан сумын Эрүүл мэндийн төв, Хараа бүс, Сайхан бүс, Ерөө бүс, Цагааннуур бүс, Сүхбаатар бүсийн нийт 8 баг ажил мэргэжлийн ур чадвар, мэдлэгээ сэргээж өрсөлдсөн. Мөн Мандал сумын нэгдсэн эмнэлэг "Цэнхэр кодоор тусламж үйлчилгээ үзүүлэх нь" сэдэвт ур чадварын тэмцээнийг зохион байгуулан 40 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулсан. | |
| | | | Дэмжлэгт хяналт үнэлгээ хийсэн тоо | 6 | 7 | 2025 онд магадлан итгэмжлэлд хамрагдсан нийт 19 эрүүл мэндийн байгууллагын сувилахуйн тусламж, үйлчилгээний чиглэлд цахим болон газар дээр очиж дэмжлэгт хяналт үнэлгээг хийж ажилласан. | 100 |
| 3.6.2 | "Сувилахуй эмнэлгийн тусгай мэргэжлийн орон тооны бус алба"-ны хурлыг зохион байгуулах, "Чадварлаг сувилагч" | Улс, орон нутгийн төсөв | "Сувилахуй эмнэлгийн тусгай мэргэжлийн орон тооны бус алба"-ны хурлыг зохион байгуулсан тоо | 3 | 3 | Эрүүл мэндийн газрын дэргэдэх сувилагч эмнэлгийн тусгай мэргэжлийн орон тооны бус албаны хурлыг цахим хэлбэрээр 2025 онд 2 удаа зохион байгуулсан. Мөн албаны хурлаас гарсан 2025 онд хийх ажлын төлөвлөгөөг гарган ажиллалаа. Мөн Олон улсын сувилагчдын баярын өдрийг тэмдэглэх хүрээнд Түнхэл тосгонд "Хүйн ээж тандаа баярлалаа" арга хэмжээг 4 зорилтын хүрээнд дараах ажлыг зохион байгуулсан. Үүнд: Түнхэл тосгонд "Хүйн ээж тандаа баярлалаа" арга хэмжээг 4 зорилтын хүрээнд, 2025 оны 06 дугаар сарын 20-ны өдөр хурлыг цахим хэлбэрээр зохион байгуулан Эх хүүхдийн эрүүл | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хөтөлбөрийг хэрэгжүүлэх | | | | | мэндийн үндэсний төвтэй хамтран ажиллах үйл ажиллагаа болон Алтанбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 100 жилийн ойн арга хэмжээний хүрээнд "Ачит эмч тандаа баярлалаа" арга хэмжээг 3 зорилтын хүрээнд зохион байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөөг гарган хэрэгжүүлж ажилласан. | |
| | | | "Чадварлаг сувилагч"-ийг бэлтгэх эмнэлзүйн сургагч багшийн тоо | 20 | 20 | Эрүүл мэндийн хөгжлийн төвийн А/96 тоот тушаалын дагуу эмнэлзүйн 22 багшийн судалгааг авч ажилласан ба Жайка олон улсын байгууллагын дэмжлэгт хөтөлбөр дууссан тул орон нутгийн санхүүжилтээр хийх сургалтын тушаалын төслийг Эрүүл мэндийн газрын даргад танилцуулсан. Шинээр суралцах эмнэлзүйн сургагч багшийн судалгааг Эрүүл мэндийн хөгжлийн төв рүү албан бичгээр хүргүүлэн ажилласан. Мөн Аймгийн нэгдсэн эмнэлгийн 2 эмнэлзүйн сургагдсан багш нар "Шинэ сувилагчдыг дадлагажуулах" 3 сарын хөтөлбөрийг боловсруулан амжилттай хэрэгжүүлэн ажиллаж байна. Тус хөтөлбөр нь 2026 онд 01 дүгээр сар хүртэл үргэлжилнэ. | 100 |
| 3.6.3 | ЭМС-ын А/513, А/41 тоот тушаалын хэрэгжилтийг ханган ажиллах | Улс, орон нутгийн төсөв | Тушаалын хэрэгжилтийн хувь | 30% | 1,2 хувиар нэмэгдүүлнэ | ЭМС-ын А/513 тушаалын хүрээнд Эрүүл мэндийн хөгжлийн төв, Монголын сувилагчдын нийгэмлэгээс зохион байгуулагдах зэрэг горилох шалгалтад 18 сувилагч, тусгай мэргэжилтнийг 2025 оны 10 сард Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 4-р сургууль, Эрүүл мэндийн газар хамтран онолын шалгалтын ubt.mn цахимаар авч ажилласан. Нийт 10 сувилагч шалгалтдаа ахлах зэргээ амжилттай хамгаалсан. Өмнөх оноос 2,8 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хувиар зэрэгтэй сувилагчийг тоог нэмэгдүүлэн ажилласан. | |
| **4.НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ** | | | | | | | |
| Зорилт 4.1. **Халдварт өвчний тандалт, сэргийлэлт, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг уян хатан, шуурхай зохион байгуулах чадавхыг тогтвортой бэхжүүлж, нэн шаардлагатай вакциныг хүн бүрд хүртээмжтэй болгож, зонхилон тохиолдох халдварт өвчний тархалтыг бууруулах”** | | | | | | | |
| 4.1.1 | Шинэ болон дахин сэргэж буй халдварын шинэ хувилбарын тархалтаас урьдчилан сэргийлэх, тандалт, ялангуяа хилийн нэвтрэх цэгтэй аймагт лабораторид суурилсан тандалт хийх, өвчлөл зөөвөрлөгдөхөөс сэргийлэх арга хэмжээг | Улсын төсвийн санхүүжилтээр | Хилийн нэвтрэх цэгт хийгдсэн шинжилгээний тоо, | 40 | 100 | Шинэ болон дахин сэргэж буй халдварын шинэ хувилбарын тархалтаас урьдчилан сэргийлэх, тандалт хийх зорилгоор Аймгийн болон Мандал сумын нэгдсэн эмнэлэг, Алтанбулаг сумын эрүүл мэндийн төв 63 сорьц аван ХӨСҮТ-ийн Томуугийн лабораторид өгөхөд 10 (15,8%) сорьцод вирус эерэг тодорхойлогдсон байна. | 100 |
| | | | эерэг гарсан хувь | 10% | 10 хувь түүнээс дээш | Вирусийн орчилд<br>A(H3N2)–1(10%)<br>A(H1N1)–1(10%)<br>АЗСВ–5(50%)<br>Риновирус–2(20%)<br>Энтеровирус1(10%) | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэрэгжүүлж ажиллах | | | | | | |
| 4.1.2 | Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хуулийг сурталчлан таниулах үйл ажиллагааг зохион байгуулах | Улсын төсвийн санхүүжилтээр | Сургалтад хамрагдсан байгууллагын тоо | - | 28 | Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хуулийг сурталчлан таниулах зорилгоор 12 сум тосгоны Засаг даргын тамгын газар, эрүүл мэнд, боловсролын байгууллагын удирдлага албан хаагч, иргэдэд сургалтыг зохион байгуулсан Тус сургалтад 12 сум, тосгоны 34 байгууллагынт 630 гаруй албан хаагч иргэд хамрагдсан. | 100 |
| | | | Сургалтад хамрагдсан иргэд, байгууллагын тоо | | 250 | | 100 |
| 4.1.3 | Товлолын дархлаажуулалтын хамралтын хувийг нэмэгдүүлсնээр зонхилон тохиолдох халдварт . | Улсын төсвийн санхүүжилтээр | Товлолын дархлаажуулалтын хамрагдалтын хувь | 98% | 98,1% | Монгол улсын Дархлаажуулалтын тухай хуулийн 10 зүйл, МУЗГ-ын 2023 оны 473 дугаар тогтоолд заасан дархлаажуулалтын үндэсний товлолд заасан заавал хийгдэх дархлаажуулалтаар 15 төрлийн халдварт өвчнөөс 9 төрлийн вакциныг хийж байгаа ба дархлаажуулалтын хамралт 95-98%-иас дээш байна.<br>Аймгийн Засаг даргын захирамжийн дагуу томилогдсон ажлын хэсэг сумдад “Хүний папиллома вирусийн халдварын эсрэг вакцин болон товлолын дархлаажуулалтын ач холбогдлын талаарх сургалтыг 420 | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | өвчнийг бууруулах | | | | | эрүүл мэндийн байгууллагын ажилтан, 357 багш ажилчид, 200 гаруй зорилтот бүлгийн хүүхдүүд, 1600 гаруй асран хамгаалагч иргэдэд хийж, анхан шатны эрүүл мэндийн байгууллагын дархлаажуулалтын хүйтэн хэлхээний дэмжлэгт хяналтыг хийж ажилласан.<br><br>Үүний үр дүнд дархлаажуулалтын хамралт нэмэгдэж хүний папиллома вирусын дархлаажуулалт 2024 оны хамралт 80%-тай, 2025 оны хамрагдалт 90%-тай болж нэмэгдсэн үзүүлэлттэй байна.<br><br>Улс даяар улаанбурхан өвчний дэгдэлт бүртгэгдэж байгаа энэ үед Улаанбурхан, гахай хавдар, улаануудын эсрэг вакциний I, II тунгаас хоцорсон хүүхдүүдэд нөхөн дархлаажуулалтыг хийж байна.<br><br>Өнөөдрийн байдлаар 1477 хүүхдийг УГУ вакцины I, II тунгаар нөхөн дархлаажуулсан. | |
| 4.1.4 | Томуугийн дархлаажуулалтын хамралтын хувийг нэмэгдүүлснээр зонхилон тохиолдох халдварт өвчнийг бууруулах | Улсын төсвийн санхүүжилтээр | Улсаас тухайн жилд дэвшүүлсэн зорилтот хүн амын хамралтын хувь | 100% | 100% | Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/334 тушаалын дагуу "Улирлын томуугийн дархлаажуулалт"-ыг 2025 оны 9 дүгээр сард нэгдсэн эмнэлэг, сум, тосгон, өрхийн эрүүл мэндийн байгууллагууд 8760 хүн тун зорилтот насны иргэдийг 100 хувь дархлаажуулсан. Үүнд: 6 сартайгаас–6 хүртэлх насны 4930 хүүхэд,<br><br>Жирэмсэн эх 94<br><br>Архаг хууч өвчтэй 1433,<br><br>65-аас дээш насны 1132 настан<br><br>Боловсролын байгууллагын 371 багш, ажилчид | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Эрүүл мэндийн байгууллагын 800 ажилтан тус тус хамрагдсан байна. | |
| 4.1.5 | Бэлгийн замаар дамжих халдварт өвчний тандалт сэргийлэлтийн ажлыг эрчимжүүлэх арга хэмжээ | Улсын төсвийн санхүүжилтээр | Нийт халдварт өвчинд эзлэх бэлгийн замаар дамжих халдвар | 76,5 | 76,0 | Тайлангийн хугацаанд 10,000 хүн амд трихомониаз 6,9, заг хүйтэн 4,5, тэмбүү 5,8 промилл байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал заг хүйтэн 1.1, тэмбүү 1,6 промиллоор өссөн, трихомониаз 0,2 промиллоор тус тус буурсан үзүүлэлттэй байна. Хүүхэд гэр бүл хөгжил хамгааллын газар, Цагдаагийн газартай хамтран "Үе тэнгийн дээрэлхэлт гэж юу вэ?", "Нөхөн үржихүйн эрүүл мэнд, бэлгийн боловсрол"-ын талаарх сургалтыг 2000 гаруй эцэг эхчүүдэд 9-12 дугаар ангийн хүүхдүүдэд 7200 хүүхдэд зохион байгуулсан.<br><br>Аймгийн засаг даргын тамгын газар, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нэгдсэн холбоотой хамтран Бэлчир бүсийн хөгжлийн бэрхшээлтэй иргэд, асран халамжлагч 110 гаруй иргэдэд "Нөхөн үржихүйн эрүүл мэнд, гэр бүл төлөвлөлт, бэлгийн боловсрол олгох" сургалтыг зохион байгуулсан.<br><br>Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/133 дугаар тушаалын хэрэгжилтийг эрчимжүүлэх, төрөлхийн тэмбүү өвчнөөс сэргийлэх зорилгоор Ерөө, Цагааннуур бүсийн 10 сум, тосгоны Эрүүл мэндийн төвүүдийн их эмч, эх баригч нарт бэлгийн замаар дамжих халдварын чиглэлээр сургалт хийж, эрсдэлт бүлгийн иргэдэд шинжилгээг хэрхэн хийх, унших, зэрэг гарсан сорьцыг хэрхэн тээвэрлэх, анхан шатны маягтыг хэрхэн бөглөх талаар арга зүйн зөвлөгөө өгч, зорилтод бүлгийн нийт 222 нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдэд ДОХ/Тэмбүүгийн хосолсон тест тавин | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | өөрчлөлттэй илэрсэн 30 хүний оношийг баталгаажуулан, шинээр илэрсэн 1 тэмбүүг эмчилгээ хяналтад авч эрүүлжүүлсэн байна.<br><br>Аймгийн Нэгдсэн эмнэлэг, “Монголын гэр бүлийн сайн сайхны нийгэмлэг” төрийн бус байгууллагатай хамтран Сайхан, Сант, Орхон сумын эрсдэлт бүлгийн нийт 117 хүнд бэлгийн замаар дамжих халдварын оношилгоог хийж, өөрчлөлттэй гарсан 34 хүний оношийг баталгаажуулан шинэ тэмбүү 2 илрүүлж эмчилгээ, хяналтад оруулж ажилласан. Тус сумын өсвөр насны хүүхдүүд болон нөхөн үржихүйн насны залуучуудад ХДХВ/ДОХ, БЗДХ-ын чиглэлээр мэдээлэл, сургалт сурталчилгааг 250 гаруй хүнд хийсэн. | |
| 4.1.6 | “Сүрьеэгүй Сэлэнгэ” хөтөлбөрийн хүрээнд сүрьеэ өвчний тандалт сэргийлэлт, эрт илрүүлгийн үзлэг оношилгоо, эмчилгээ хяналтыг сайжруулах, тархалтыг | Улсын төсвийн санхүүжилтээр | Сүрьеэгийн өвчлөлийн түвшин 10000 хүн амд | 10.1 | 10,0 | Аймгийн хэмжээнд сүрьеэ өвчний шинэ тохиолдол 2025 оны 11-р сарын байдлаар 78 буюу 10000 хүн амд 7,4 байна. Энэ нь мөн оны мөн үеэс 0,4 промиллоор буурсан үзүүлэлттэй байна. Сум, тосгоны эрүүл мэндийн төвүүд орон нутгийн удирдлага, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, аж ахуйн нэгжүүдэд зориулан "Тийм ээ, Бид сүрьеэг устгаж чадна" сэдвээр лекц, уулзалт, арга хэмжээг амжилттай зохион байгуулж, нийт 360 хүнийг хамруулллаа. Сүрьеэгийн эмчилгээний амжилт 84,6% байна.<br><br>Анхан шатны эрүүл мэндийн төвд ажиллаж буй сүрьеэ өвчний асуудал хариуцсан 30 ажилтанд зориулан шинэчлэгдсэн удирдамж, эмчилгээний аргачлал, урьдчилан сэргийлэлт, хяналтын чиглэлээр танхимийн сургалт зохион байгууллаа. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | бууруулах арга хэмжээ | | | | | Далд хэлбэрийн сүрьеэг илрүүлэх зорилгоор Монголын сумын эмч мэргэжилтний холбоотой хамтран эрсдэлт бүлгийн иргэдэд чиглэсэн "Хаалганаас хаалганд" сүрьеэгийн эрт илрүүлгийн үзлэгийг Мандал, Хэрх, Түнхэл, Цагааннуур, Зүүнбүрэн, Жавхлант, Хүдэр, Шаамар, Алтанбулаг, Сайхан, Ерөө сум, тосгон, Болд төмөр Ерөө гол ХХК-д зохион байгуулж, нийт 5333 иргэнийг хамруулахад долоон шинэ тохиолдлыг илрүүлсэн. | |
| **Зорилт 4.2. Зонхилон тохиолдох халдварт бус өвчин, тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлийн тархалт болон сэргийлж болох нас баралтыг хувь хүн гэр бүл хамт олон, байгууллагын идэвхитэй, оролцоотой нэгдмэл үйл ажиллагаанд тулгуурлан бууруулах.** | | | | | | | |
| 4.2.1 | Хүн амын дунд зонхилон тохиолдож буй халдвар бус өвчин (элэг, хөх, умайн хүзүүний хорт хавдар, чихрийн шижин, цусны даралт зэрэг)-ний эрт илрүүлэх үзлэг, шинжилгээнд иргэн бүрийг хамруулах, иргэдэд өгөх | Орон нутгийн төсөв | 18-аас дээш насны иргэдийн хамрагдалтын хувь | 66.7% | 67% | Артерийн гипертензийн эрт илрүүлэгт нийт 53066 хүн буюу 73,0%, чихрийн шижин хэв шинж – 2 эрт илрүүлэгт нийт 52098 хүн буюу 71,7%, элэгний хорт хавдрын эрт илрүүлэгт нийт 44094 хүн буюу 60,7%, хөхний хорт хавдраас сэргийлэх эрт илрүүлэгт нийт 10508 хүн буюу 51,2%, умайн хүзүүний хорт хавдраас сэргийлэх эрт илрүүлэгт нийт 2454 хүн буюу 34,1 %-тай -тай тус тус хамрагдсан байна. Умайн хүзүүний эрт илрүүлгээр Asc-Us – 259, Asc-H – 59, Lsil – 76, Hsil – 8 тус тус шинэ илэрсэн өвчлөлийг лавлагаа шатны эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хамруулж, эмчилгээ хяналтад авч ажиллаж байна. Эрт илрүүлэг үзлэгийн ач холбогдлын талаар сургалт сурталчилгааг 2500 гаруй хүнд хийж ажилласан. | 100 |
| | | | 30-60 насны эмэгтэйчүүдийн хамрагдалтын хувь | 47.2% | 50% | | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | мэдээлэл, сургалт, сурталчилгааг эрчимжүүлэн салбар хоорондын уялдааг хангаж ажиллах | | | | | | |
| 4.2.2 | Анхан шатны эрүүл мэндийн байгууллагад халдварт бус өвчин, тэр дундаа зүрх судасны өвчнөөс сэргийлэх, хянах нэн шаардлагатай тусламж үйлчилгээний багц МонПэн болон мобайл технологи ашиглан тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа | Улс, орон нутгийн төсөв | Зорилтот бүлгийн хүн амын хамрагдсан тоо, хувь | - | 10% | Эрүүл мэндийн үзлэгт хамрагдаж чаддаггүй алслагдсан, хөдөлгөөнт ба эмзэг бүлгийн хүн амд анхан шатны тусламж үйлчилгээг мобайл технологийг ашиглан халдварт болон халдварт бус өвчний эрт илрүүлэг оношилгоог хийх зорилгоор 2025 онд 15 сум, 6 тосгон, 5 өрхийн эрүүл мэндийн төвд мобайл тусламж, үйлчилгээг зөөврийн ЭХО аппарат болон зүрхний ЭКГ, явуулын дархлаажуулалт, элэгний В, С болон түргэвчилсэн оношлуур, уушигны үйл ажиллагааг хэмжигч спирометр зэрэг багажийн тусламжтай тусламж үйлчилгээг аймгийн хэмжээнд нийт 23 өрх, 108 хүнд хүрч үйлчилсэн байна.<br><br>Зүрх судасны өвчнөөс сэргийлэх, хянах нэн шаардлагатай тусламж үйлчилгээний багц МонПэн төслийг ДЭМБ-ын байгууллагын санхүүжилтээр ЭМЯ, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвтэй хамтран 2025 оны 9 дүгээр сард 28 эрүүл мэндийн байгууллагын 74 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд зүрх судасны нэн шаардлагатай тусламж үйлчилгээний багц арга хэмжээг нэвтрүүлж, анхан шатны бүртгэл хяналтын тогтолцоо mncardio цахим программ ашиглан оношилгоо, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | байдалд хяналт тавьж ажиллах | | | | | эмчилгээний шинэ арга аргачлал, эмнэлзүйн зааврын мэдээллээр хангагдаж өвчний хяналтын эргэн дуудах болон эрүүл мэндийн мэдээлэл сурталчилгаа нэвтрүүлэх үйл ажиллагаа хэрэгжиж эхэлсэн байна. Одоогоор 17 сум 6 тосгон, 5 өрхийн эрүүл мэндийн байгууллагууд тогтмол ажилуулж, 1048 иргэдийг хяналт тавьж ажиллаж байна. | |
| 4.2.3 | Улс орон даяар зохион байгуулагдаж байгаа урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгт өөрийн харьяа нутаг дэвсгэр дэх хүн амыг насны бүлгээр бүрэн хамруулах, энэ чиглэлд ажил олгогчид болон салбар дундын хамтын ажиллагааг хангаи манлайлж ажиллана. | Улс, орон нутгийн төсөв | Эрт үзлэгт хамрагдсан иргэдийн хамрагдалтын хувь | 42% | 45% | "Эрүүл Монгол хүн" цогц арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээнд урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, үзлэг, оношилгоонд 48345 /45,2%/ иргэн буюу<br>0-5 насанд 8752 хүүхэд 68,6%<br>6-17 насанд 21522 хүүхэд 86,7%<br>18-30 насанд 3023 иргэн 16,4%<br>31-45 насанд 5868 иргэн 25,7%<br>46-60 насанд 6301 иргэн 33,6%<br>61-ээс дээш 2879 иргэн 31,3% үүнээс эрэгтэй 44,3%, эмэгтэй 55,7% тус тус хамрагдсан байна.<br>Эрүүл мэндийн даатгалын сангаас 458.400.000 төгрөгийг зарцуулсан. Тус эрт илрүүлэг үзлэгийг эрчимжүүлэх хүрээнд сумын засаг дарга, тосгоны захирагч нарт эрүүл мэндийн газрын даргын 393 тоотоор хүргүүлэн ажиллаж байна.<br>Өөрийн орон нутгийн 20 гаруй төрийн болон төрийн бус байгууллагын ажилчдыг тус эрт илрүүлэг үзлэгт хамруулан ажилласан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.2.4 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлэн эрүүл мэндийн байгууллагын гадаад, дотоод орчны тохижилт (тэргэнцэрт зориулсан үүдний хэсэг, хананы бариул, дуугүй хөтөч, тусгайлсан жорлон, дуут дохио гэх мэт)-д үнэлгээ хийж үнэлгээний мөрөөр шаардлагатай арга хэмжээ төлөвлөн | Орон нутгийн төсөв | Хөгжлийн бэрхшээлтэй иргэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлэн эрүүл мэндийн байгууллагын тоо | 3 | Тухай бүр | Сэлэнгэ аймгийн эрүүл мэндийн салбарын хэмжээнд 10 эрүүл мэндийн байгууллага хөгжлийн бэрхшээлтэй иргэнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах нөхцлийг бүрдүүлж, налуу зам, таяг, тэргэнцэр, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зориулсан ариун цэврийн өрөө, баррель үсэг, дуугүй хөтөч, хананд барьж явах бариул, хэвтэн эмчлүүлж байгаа иргэдэд толгой угаах цомог, хоол идэх цомог, 00 өрөө, дуут хонх зэргийг шинээр байгуулан, гэрээр эргэх иж бүрэн цомгийн бүрдэлтэй болж 26,959,700 төгрөг зарцуулсан байна.<br><br>Япон улсын засгийн газрын санхүүжилтээр Японы хүүхдийг ивээх сантай хамтарч Тэгш хүртээмжтэй цогц үйлчилгээгээр бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих нь төслийг 2025 оны 05 сараас аймагт хэрэгжиж байна. Төслийн хүрээнд Номтхан өрхийн эрүүл мэндийн төв, 3-р цэцэрлэг зэрэг зорилтот газруудыг сонгон тусгай хэрэгцээт иргэдэд зориулсан тоног төхөөрөмж, налуу шат, засвар үйлчилгээ хийгдсэн. Төслийн хүрээнд зорилтот цэцэрлэг, эрүүл мэндийн байгууллагын эмч, багш, мэргэжилтнүүдэд хөгжлийн бэршээлтэй иргэдтэй хэрхэн харьцах, хөдөлгөөн засал, сэргээн заслын сургалт, хийгдэж байна. Үр дүн:<br><br>Хөгжлийн бэрхшээлтэй иргэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах нөхцлийг бүрдүүлэн ажилласнаар, эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмж нэмэгдсэн байна. | 100 |
| | | | Зарцуулсан хөрөнгийн хэмжээ | 15сая төгрөг | Зарцуулсан хөрөнгийн хэмжээгээр | | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэрэгжүүлж ажиллах | | | | | | |
| 4.2.5 | “Эрүүл шүд”, “Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах”, Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, Сэтгэцийн эрүүл мэнд зэрэг арга хэмжээг хэрэгжүүлж, иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, эрүүл | Арга хэмжээний зардлын төсөв | Сургалт сурталчилгаа, зөвлөгөө, мэдээлэлд хамрагдсан хүний тоо | 20038 | 25000 | -Эрүүл идэвхтэй амьдралын хэв маягийг төлөвшүүлж Эрүүл монгол хүн, Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах, Эрүүл шүд, Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, “Сэтгэцийн эрүүл мэнд” арга хэмжээнүүдийн хүрээнд 95 арга хэмжээ төлөвлөснөөс энэ жил 86 арга хэмжээг 90,9%-тай хэрэгжүүлсэн байна. Үүний хүрээнд дараах ажлууд зохион байгуулагдсан байна. Үүнд<br>- Шүд угаалтын аймгийн аварга шалгаруулах тэмцээн<br>-24/3 аян шүдээ угаая сарын аян<br>-Хүний папиллома вирусийн эсрэг дархлаажуулалтыг нэмэгдүүлэх сургалт<br>-Осол гэмтлээс сэргийлэх “Аюулгүй байдлын төлөө үгээ хэлцгээе” аян<br>-Жендерт суурилсан хүчирхийллээс сэргийлэх 16 хоногийн аян | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | амьдралын хэв маягийг төлөвшүүлнэ. | | | | | -Эрүүл эрсдэлгүй наадъя гэх мэт үйл ажиллагааны хүрээнд бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд хамтдаа 19 төрлийн 41 удаагийн зорилтот сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж 41544 иргэнийг хамруулсан. | |
| 4.2.6 | Хүн амын дунд эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлэх чиглэлээр сургалт, сурталчилгаа нөлөөллийн арга хэмжээг иргэн, аж ахуй нэгж байгууллага төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулах | Арга хэмжээний зардлын төсөв | Сургалтад хамрагдсан нийт хүн амын эзлэх хувь | 3,9% | 5% | 2025 оны байдлаар хүн амын дунд эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлэх чиглэлээр 32 удаагийн танхимын сургалтыг зохион байгуулж аймгийн нийт хүн амын 35.6% буюу 38146 хүнийг хамруулаад байна. Үүнд:<br>Бага насны хүүхдийн эрт илрүүлэг үзлэг, дархлаажуулалт, сургууль, цэцэрлэгийн үдийн хоол, илчлэг тооцох аргачлал, яаралтай тусламж, эрүүл зохистой хооллолт хоол тэжээл, хүнсний аюулгүй байдлын зөвлөмж, гэр бүл төлөвлөлт, нөхөн үржихүйн эрүүл мэнд, сүрьеэ, гэмтлийн тусламж үйлчилгээг сайжруулах, чихрийн шижингийн өөрийн хяналт, анхаарах асуудал, амны хөндийн эрүүл мэнд, архинд донтох эмгэгтэй иргэдэд чиглэсэн уулзалт, ажлын байран дахь бэлгийн дарамтаас сэргийлэх, гэр бүл төлөвлөлт, үр хөндөлтийн хор уршиг, бэлгийн замаар дамжих халдвараас сэргийлэх нь зэрэг сургалт, нөлөөллийн ажлууд багтсан ба сургалт, арга хэмжээний үр дүнд дээд шатлалын эмнэлгүүд, төр, хувийн хэвшлийн байгууллагуудын уялдаа, хамтын ажиллагаа сайжирч, нийт иргэдийн 35,6%-д хүрч ажиллалаа. | 100 |
| | | | Сургалтад хамрагдсан нийт хүн амын тоо | 4212 | 5400 | | 100 |

<table>
<tr><td rowspan="2">4.2.7</td><td rowspan="2">Сэтгэцийн эрүүл мэнд, ялангуяа хүүхэд, өсвөр үеийнхэнд сэтгэлзүйн тусламж, үйлчилгээг үзүүлэх, сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, архи, тамхи, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөл, түүний талаарх мэдлэг олгох, хэрэглээг бууруулах, урьдчилан сэргийлэх, осол, гэмтлээс сэргийлэх (ахуйн орчны осол гэмтэл, уналт, автотээврийн гэх мэт) зэрэг салбар дундын</td><td rowspan="2">Арга хэмжээний төлөвлөгөөний зардлаас</td><td>сургалтад хамрагдсан иргэдийн тоо</td><td>1500</td><td>2000</td><td rowspan="2">Аймгийн эрүүл мэндийн газрын даргаар батлуулсан 2024-2027 онуудад хэрэгжүүлэх “Сэтгэцийн эрүүл мэнд” арга хэмжээний төлөвлөгөөг 4 зорилтын хүрээнд 8 арга хэмжээг төлөвлөн 80 хувийн биелэлттэй ажиллаж байна.<br><br>“Электрон тамхины хэрэглээ” сэдвээр 54 удаагийн сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулж, 10 төрлийн сурталчилгааны материалыг тараан, Өсвөр үеийг ойлгох, нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрүүл хооллох, сэтгэцийн эрүүл мэндийн чиглэлээр 9100 гаруй сурагчдыг хамруулсан. Бүх шатны эрүүл мэндийн байгууллагуудын эрүүл мэндийн газрын фэйсбүүк, вэйб сайт хуудсаар дамжуулан 26 төрлийн мэдээллийг 4200 удаа хуваалцаж, 9800 гаруй иргэдийн хандалт авсан үзүүлэлттэй байна.<br><br>2,4,6 дугаар сургууль, 6-р цэцэрлэгийн сурагч, эцэг эхчүүд нийт 631 хүнд эрүүл амьдралын хэв маягийн чиглэлээр сургалт, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвөөс өрнүүлсэн "Сэтгэл ч бас өвддөг - анзаараарай" нөлөөллийн арга хэмжээний хүрээнд эрүүл мэндийн байгууллагууд 15 төрлийн контентыг олон нийтэд түгээж 1650 таалагдсан сэтгэгдэл, 64000 гаруй хүнд хүрсэн үзүүлэлттэй байна.<br><br>Цагдаагийн байгууллагатай хамтран 2025 оны 1 дүгээр сард "Агшин бүрт анхаарал сэрэмжийг нэмж эрсдэлийг бууруулъя" сарын аяныг өрнүүлж, нийтийн үйлчилгээний такси болон олон нийтийг хамарсан үйлчилгээний газруудад архи, тамхи, сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах мөлхөө сурталчилгааг өрнүүлж, сэргийлж</td><td>100</td></tr>
<tr><td>Цахим сургалт хамрагдсан хүний тоо</td><td>2500</td><td>3500</td><td>100</td></tr>
</table>

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хамтын ажиллагааг хангаан хамтран ажиллах | | | | | болох осол, эндэгдлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр аймгийн хэмжээнд 28000 гаруй иргэдэд хүрч ажилласан.<br><br>2025 оны 05 сарын 30-нд Тамхидалтын эсрэг дэлхийн өдрийг тэмдэглэн өнгөрүүлж, 500 гаруй өсвөр насны хүүхэд, эцэг эх асран хамгаалагчдад тамхи, электрон тамхи, түүний хор нөлөө, эрүүл мэндийн эрсдэлийг ойлгуулан таниулах нөлөөллийн өдөрлөг амжилттай зохион байгууллаа.<br><br>Дээрх сургалт нөлөөллийн ажлын сумдын ЗДТГ, Цагдаагийн газар, Боловсролын газар, Хилийн цэргийн 101, 0243, Хүүхэд гэр бүлийн хөгжил хамгааллын газар, Хатан Замнал ТББ, Ахмадын хороо зэрэг бусад төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулсан | |
| ***Тав. Салбарын хяналтад хэрэгжүүлж буй эрх зүйн орчныг боловсронгуй болгож, хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлж хууль тогтоомж тэдгээртэй нийцүүлэн гаргасан дүрэм,журам, стандартын хэрэгжилтийг хангуулах, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх ажлын хүрээнд*** | | | | | | | |
| 5.1. | Эрүүл ахуй, халдвар хамгааллын 4 хяналтын чиглэлээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 33 | Улсын төсөв | Объектын хамрагдалт | 100% | 100% | Хяналт, үнэлгээний үндэсний хорооны 2024 оны 02 дугаар тогтоолоор батлагдсан Салбарын хяналтын 2025 онд хэрэгжүүлэх хяналт шалгалтын төлөвлөгөө, Эрүүл мэндийн яамны Салбарын хяналтын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-нд тусгагдсан Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын 4 чиглэлээр 33 объект буюу 100%-ийг хамруулсан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | объектод төлөвлөгөөт хяналт шалгалт хийх | | Эрсдэлийн түвшин | 45.5% | 1.5% хүртэлх бууруулна | Төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдсан нийт 33 объектын эрсдэл үүсэх магадлал 43.82% буюу өмнөх үеийн хяналт шалгалтын үзүүлэлттэй харьцуулахад 1.68%-иар буурсан байна. | 100 |
| | | | Хууль тогтоомжийн хэрэгжилт | 54.5% | 1.5% хүртэлх нэмэгдүүлнэ | Төлөвлөгөөт хяналт шалгалтаар нийт 968 заалт бүхий 25 албан шаардлагыг хугацаатай хүргүүлж, хяналт шалгалтад хамрагдсан 20 аж ахуйн нэгж, байгууллагад 44.000.000 төгрөгийн шийтгэлийн арга хэмжээг авч 100% барагдуулсан. Хууль сахин мөрдөлтийн өмнөх онтой харьцуулахад 57.54% буюу 3.04%-иар нэмэгдсэн үзүүлэлттэй байна. | 100 |
| 5.2 | Эрүүл ахуй, халдвар хамгааллын 4 хяналтын чиглэлээр 15 удирдамжийн хүрээнд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх | Улсын төсөв | Шийдвэрлэлтийн хувь | 100% | 100% | Эрүүл ахуй, халдвар хамгааллын 4 хяналтын чиглэлээр 15 удирдамжийн хүрээнд нийт 501 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг хамруулж, итгэмжлэгдсэн лабораторит 249 дээжийг 2056 үзүүлэлтийн хүрээнд шинжилгээнд хамруулахад 112 буюу 5.45% нь зөрөг гарч, 243 заалт бүхий 18 улсын ахлах байцаагчийн зөвлөмж болон 4 албан тоотоор чиглэл хүргүүлэн эрүүл ахуй, стандартын шаардлага хангахгүй тухай 27 газрын даргын албан тоотоор тус тус хүргүүлж ажилласан. | 100 |
| | | | Зөрчил арилгуулалтын хувь | 42.7% | 1.5% хүртэлх нэмэгдүүлнэ | Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын явцад нийт 1186 зөрчил, дутагдлыг илрүүлж үүнээс 588 буюу 50.4%-ийг арилгуулсан, 332 заалт бүхий 22 албан шаардлагыг хугацаатай хүргүүлж биелэлтийг тооцоход 57.8%-тай, өмнөх онтой харьцуулахад 15.1%-иар нэмэгдсэн үзүүлэлттэй байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Хууль тогтоомжийн хэрэгжилт | 68.9% | 1.5% хүртэлх нэмэгдүүлнэ | Эрүүл ахуй, халдвар хамгааллын 4 хяналтын чиглэлээр 15 удирдамжийн хүрээнд нийт 501 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг хамруулж, Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтыг үндэслэн 22 иргэн, аж ахуйн нэгжид 17.650.000 төгрөгийн шийтгэлийн арга хэмжээг тооцож Захиргааны хэрэг хянан шийвдэрлэх шүүх ажиллагаагаар 1 аж ахуйн нэгжийн 3.000.000 төгрөгийн шийтгэлийн арга хэмжээг хүчингүй болгож, 14.650.000 төгрөгийн шийтгэлийн мөнгийг 100% барагдуулж ажилласан. Хяналт шалгалтаар хууль сахин мөрдөлт 71.86%-тай өмнөх онтой харьцуулахад 2.9%-иар нэмэгдсэн үзүүлэлтэй байна. | 100 |
| 5.3 | Бүх шатын боловсролын байгууллагын хоол үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд аймгийн Стандарт хэмжилзүйн хэлтсийн бүтээгдэхүүн баталгаажуулалтын холбогдох мэргэжилтнүүдтэй хамтарч | Улсын төсөв, орон нутгийн төсөв | Нийт объектын хамрагдалт | - | 20 | Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичиг “Алсын хараа 2050”, “Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих үндэсний хөтөлбөр 2020-2025”, Сэлэнгэ аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 16 дугаар тогтоолоор батлагдсан “Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т 17 сум, 6 тосгонд байрлах бүх шатын боловсролын 78 байгууллагын, 22 эрүүл мэндийн байгууллагын нийт 100 байгууллагын хоол үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын Хяналтын хэлтсийн Хүнсний чанар, стандартын хяналтын улсын байцаагч, Стандарт хэмжилзүйн хэлтсийн бүтээгдэхүүн баталгаажуулалтын холбогдох мэргэжилтнүүдтэй хамтарч 100% хийж гүйцэтгэсэн. | 100 |
| | | | Шаардлага хангасан | - | 10 | Хоол үйлдвэрлэлийн стандартын шаардлага хангасан ерөнхий боловсролын сургуулийн 10, сургуулийн өмнөх | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | үнэлгээ хийх, үдийн хоолны илчлэг, шимт бодисын хэмжээнд тооцооллын аргаар үнэлэлт дүгнэлт өгөх | | хоол үйлдвэрлэлийн тоо | | | боловсролын 14, дотуур байрны 1, эрүүл мэндийн байгууллагын хоол үйлдвэрлэлийн ажлын байранд 9 нийт 34 байгууллагад Стандарт хэмжилзүйн хэлтсийн баталгаажуулалт хариуцсан мэргэжилтэн стандартын шаардлага хангасан тохирлын гэрчилгээг даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж олгохоор шийдвэрлэсэн. | |
| | | | хоолны илчлэг, шимт, бодисын хэмжээ | 400 ккал | 420 ккал | Хоолны илчлэгийн хэмжээг тооцооллын аргаар гаргаж аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд 2025 оны 12 дугаар сарын 30-ны дотор танилцуулахаар бэлтгэл хангаж байна. | 100 |
| 5.4 | Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өргөдөл, хүсэлт,гомдол, мэдээлэл, эрх бүхий байгууллагын шийдвэрээр төлөвлөгөөт | Улсын төсөв | Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тоо | 5 | 100% | Тайлангийн хугацаанд нийт 6 өргөдөл гомдлыг хүлээн авч газрын даргын баталсан төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх тухай удирдамжийн дагуу 100% хийж гүйцэтгэсэн. | 100 |
| | | | Зөрчлийн хувь | 75% | 1% хүртэлх нэмэгдүүлнэ | Төлөвлөгөөт бус хяналт шалгалтын явцад 3 албан шаардлагыг 45 заалттай өгч өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг тооцож ажиллахад 76.8%-тай, өмнөх онтой харьцуулахад 1.8%-иар нэмэгдсэн, холбогдох иргэн, аж ахуйн нэгжид 6 албан тоот, 1 мэдэгдлийг хүргүүлсэн. Илэрсэн зөрчилд Монгол Улсын Зөрчлийн тухай хуулийн дагуу 8.000.000 төгрөгийн шийтгэлийн арга хэмжээ авч 896.000 төгрөгийн нөхөн төлбөр тооцож төлбөрийг 100% барагдуулсан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | бус хяналт, шалгалт хийх | | | | | | |

Тайланг үнэлсэн: Төсвийн Ерөнхийлөн захирагч

Аймгийн Засаг дарга ......................... / Н.Лхагвадорж /
(албан тушаал) (гарын үсэг)
(огноо)

Тэмдэг

............................

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн: Нэгжийн дарга

ХШҮХ-н дарга ......................... / Л.Төгөлдөр /
(албан тушаал) (гарын үсэг)
(огноо)

..............................

Тайлагнасан: Төсвийн шууд захирагч

Эрүүл мэндийн газрын дарга ......................... / Ж.ОД /
(албан тушаал) (гарын үсэг)

(огноо)
2025-12-15